



ГАРЧИГ

- 1–3** Бодлогын нийтлэл
- 4–5** Зохицуулалтын мэдээ
- 6–8** Байр суурь
- 9** Уур амьсгал, байгалийн доголдлын эсрэг мод тарих хөдөлгөөн
- 10** 2021 оны финтек салбарын онцлох үйл явдлууд
- 11–15** Холбоо хамаарлаас үүсэх системийн эрсдэл
- 16–18** Санхүүгийн боловсрол
- 19–20** Компанийн засаглал
- 21–22** 2021 оны өргөдөл гомдлын тайлан
- 23–24** Олон улсын зах зээлийн мэдээ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтад оруулж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг хянаж зохицуулдаггүй, мөнгө угаах эрсдэлд өртөх өндөр зэргээс шалтгаалан дээрх салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг бүртгэлжүүлэх, тусгай зөвшөөрөл олгож хянаж, зохицуулах үүрэг даалгавар өгсөн.

Дээрх чиглэлийн бодлого стратеги, зохицуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ болох үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

Ийнхүү Санхүүгийн зохицуулах хороо хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, ФАТФ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг хянаж зохицуулах дүрэм журмыг баталж, 2021 оны байдлаар нийт 40 хуулийн этгээд, 436 иргэнд дээрх төрлийн тусгай зөвшөөрлийг олгож,

хяналт тавин ажилласан. Мөн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгосон нь Монгол Улсад үнэт металл, үнэт чулууны салбарт олборлох, боловсруулах, арилжаа эрхлэх, цэвэршүүлэх, эдлэл үйлдвэрлэх, худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг анх удаа нэгдсэн бодлого, зохицуулалтад хамруулсан үйл явдал болсон.

Монголбанк 2021 онд нийт 21 тонн үнэт металл худалдан авснаас 9.9 тонн буюу 47.1 хувийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 95 иргэдээс худалдан авсан бөгөөд урьдчилсан гүйцэтгэлээр тэдгээр иргэд нь нийт 753.1 тэрбум төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлсэн байна. Үүнээс үзэхэд энэ төрлийн үйл ажиллагааг хянаж, зохицуулах хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлснээр гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн ханшийг дэмжих, далд эдийн засгийг ил болгох зэрэг эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нэлээд өндөр байна. Мөн үнэт металл, үнэт эдлэлийн арилжаа эрхлэгч, үнэт металаар үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, уран дархан, тансаг зэрэглэлийн брэндийн цаг, гоёл чимэглэлийн бүтээгдэхүүн борлуулагч хуулийн этгээдүүдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр билээ.



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

АШИГТ АЖИЛЛАГААНД ХҮРЭХ ТҮВШИН

Үйл ажиллагааны орлогоороо зардлаа бүрэн нөхөж ашигт үйл ажиллагаанд хүрэх орлогын тодорхой түвшний хэмжээ.

/Эдийн засагт хугарлын цэг гэж нэрлэдэг/



BREAK-EVEN POINT

A revenues and costs in relation to sales and determines the level of sales at which the activity will begin to make a profit.

*Эх сурвалж:
Банк санхүүгийн тайлбар толь бичиг*

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ АРГА ХЭМЖЭЭ

Өмнөх нь 1-р нүүр

Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 01 –ний өдрийн А-62/63/31/А26 дугаар хамтарсан тушаалаар “Монгол улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ыг баталсан. Тус бодлогын баримт бичгийн 2021–2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний

арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай анхдагч хуулийн төслийг боловсруулахаар олон улсын зөвлөх сонгон шалгаруулан хуулийн төсөл боловсруулах хүрээнд нэр бүхий 5 улсын /Энэтхэг, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Сингапур, Канад, Арабын Нэгдсэн Эмират/ эрх зүйн орчны судалгааг хийж, тайланг гаргалаа. Хуулийн төслийн анхны хувилбарт



төлөвлөгөөний 4.17–д үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан хууль, дүрэм, журмын төслийг боловсруулахаар тусгасан бөгөөд үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн

Монгол Улсын нутаг дэвсгэрт үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх, арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар боловсруулж байгаа бөгөөд хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар нарийвчлан



тусгалаа. Үүнд:

- 1.Хуулийн зорилт, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт зэрэг нийтлэг үндэслэл;
- 2.Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийг бүртгэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага;
- 3.Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг бүртгэх, сорьц тогтоох, гарал үүслийн ил тод байдал;
- 4.Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх арилжаа эрхлэгчид тавигдах шаардлага, хориглосон үйл ажиллагаа;
- 5.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа;
- 6.Нягтлан бодох бүртгэл, аудит, татвартай холбоотой харилцаа;
- 7.Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлага зэрэг болно.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарыг үр дүнтэй зохицуулж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлснээр хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, зохицуулалттай этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үндэсний брэндийг олон улсын зах зээлд гаргах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зэрэг давуу тал бий болгон салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж тооцож байна.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 213 дугаар тушаалаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны зохицуулалтын стратеги бодлого, хууль тогтоомж болон оролцогчдын үйл ажиллагааны дүрэм, журам, дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт, стандартыг боловсронгуй болгох, учирч болзошгүй эрсдэлээс зах зээлд оролцогчдыг хамгаалах чиг үүрэг бүхий Санхүүгийн зохицуулах хорооны газар, нэгжийн төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Мөн үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төслийг дагаж гаргах дүрэм, журам, салбарын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд ажлын албаны даргын 2021 оны №А/62 тушаалаар “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх баг”-тай гэрээ байгуулсан бөгөөд 2022–2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх иргэн хуулийн этгээдийн борлуулалтын мэдээг ХУР системээс хүлээн авах орчныг бүрдүүлэхээр “Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн QR, И–баримтын мэдээ”–ний загварыг боловсруулан ажиллаж, тусгай зөвшөөрөлтэй 396 иргэн, хуулийн этгээдэд цахим төлбөрийн баримт үүсгэх QR кодыг олгосон байна.

Газар дээрх үзлэг, шалгалтын төлөвлөгөөний дагуу нэр бүхий 2 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд, 101 иргэний үйл ажиллагааг хянаж, үүрэг даалгавар өгч ажиллаа.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд:

Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд эрх олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж, 42 оролцогчдыг хамрууллаа. Мөн үнэт металл үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд зориулсан гарын авлага болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын дүрэм, журмын эмхэтгэлийг хэвлүүлэн гаргаж, хүргүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтраад Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 38 хуулийн этгээд болон 135 иргэнд “Зөвлөмж” хүргүүлэн ажилласан байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЦАНГ ЦОХИЛОО



“Омни актив ТЗК” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны цан цохин ёслол өнөөдөр боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай, “Омни капитал ББСБ” ХХК-ийн ТУЗ-ын дарга Ч.Эрэлхэг, “Омни актив ТЗК”-ийн ТУЗ-ын дарга С.Бямбасүрэн, “Апекс капитал ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Лхамдолгор болон холбогдох бусад албаныхан оролцлоо.

Цан цохих ёслолыг нээж Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц “Санхүүгийн зохицуулах хорооноос дэд бүтцийн байгууллагууд, зах зээлийн холбоод, мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, тэр тусмаа цоо шинэ зах зээл буюу биржийн бус зах зээлийг бий болгох, банкны реформыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр бодлогын томоохон арга хэмжээнүүдийг үе шаттайгаар, цаг тухай бүрт нь авч хэрэгжүүлсний үр дүнд 2021 онд зах зээлийн хөгжлийн суурь үзүүлэлтүүд өсөж, өнгөрсөн 01 дүгээр сард хөрөнгийн зах зээлийн үнэлгээ түүхэн дээд түвшинд буюу 6 их наяд төгрөгт хүрээд байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль батлагдсанаас хойш 10 гаруй жилийн хугацаанд зөвхөн орон сууцны зээлээр баталгаажсан хөтөлбөрийн шинжтэй баталгаат үнэт цаасыг хаалттай хүрээнд цөөн тооны хөрөнгө оруулагчдад, худалдахаар гаргадаг байсан. Харин сүүлийн жилүүдэд бусад төрлийн зээл, үүрэн телефоны дараа төлбөрт

хэрэглэгчдийн төлбөр, орон сууцны түрээсээр баталгаажсан зэрэг мөнгөн урсгал бий болгох боломжтой хөрөнгөд суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргаж байна. Түүнчлэн өнгөрөгч онд банк бус санхүүгийн байгууллагаас арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулж, олон нийтэд анх удаа нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг амжилттай



гаргасан. Өөрөөр хэлбэл хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хувьцаа, өрийн хэрэгслийн адил санхүүжилт татах нэгэн төрлийн хэрэгсэл болсноор аж ахуй нэгжүүдээс энэ төрлийн үнэт цаас гаргах сонирхол нэмэгдэх болсон.


Харин энэ удаагийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь 3 өөр төрлийн зээлээр баталгаажсан гэдгээрээ онцлог бөгөөд энэ төрлийн үнэт цаасны салбарт шинэ бүтээгдэхүүн болж байна. Санхүүгийн зохицуулах хороо цаашид ч хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, үнэт цаас гаргагчид тусгай



зөвшөөрөл олгох харилцаатай холбоотой журмыг зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, олон улсын жишигт нийцүүлж илүү таатай, тодорхой, ойлгомжтой болгох зорилгоор зах зээлийн

мэргэжлийн оролцогчдынхоо саналыг авч, журмын төслийг боловсруулж байна” гэдгийг онцолсон юм.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА ГАРЛАА



Санхүүгийн зохицуулах хороо Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага “ЖАЙКА”-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх II үе шатны төсөл”-ийн хүрээнд “Монгол Улсын биржийн бус зах зээл – Шинэ зах зээл, шинэ боломж” гарын авлага гаргалаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 995 дугаар тогтоолоор “Биржийн

бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталснаар дотоодын санхүүгийн зах зээлд цоо шинээр биржийн бус зах зээл үүссэн. Энэхүү гарын авлага нийт 5 бүлэг, дэд сэдвээс бүрдсэн бөгөөд биржийн бус зах зээлийн үндсэн чиг үүрэг, дотоодын компанийн бондын зах зээлийн бүтэц, биржийн бус зах зээлийн эрх зүйн орчин, шинэчлэл, харилцагчийг таньж мэдэх (KYC) үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ болон санхүүгийн зээлжих зэрэглэл тогтоох байгууллагын үүргийн талаарх сонирхолтой мэдээллүүдийг багтааснаараа онцлог юм.

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫГ ШИНЭЧИЛЖ БАЙНА

УИХ-ын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5-д зааснаар Хороо нь санхүүгийн зах зээлд компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох үндсэн зорилгыг хангах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос 2007 онд “Компанийн засаглалын кодекс”-ыг батлан компанийн засаглалын талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, уг зарчмуудыг хэрэгжүүлэх үндсэн суурийг тавьж, улмаар 2014 онд шинэчилсэн.

Манай улсад компаниудын оролцогч талуудын чадамж харилцан адилгүй, компанийн дотоод эрх зүйн зохицуулалт төдийлэн хангалттай биш, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага тодорхой бус зэргээс

хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох явдал цөөнгүй гарч байв. Иймд компанийн засаглалын тулгуур зарчмуудад тулгуурлаж санхүүгийн зах зээлийн үндэсний онцлог, тулгарч буй хүндрэлтэй асуудлуудад тохирсон нэмэлт шаардлага, шалгуурыг бий болгож, тэдгээрийг хэрэгжүүлэх шаардлага нэгэнт үүссэн тул Хорооноос “Компанийн засаглалын кодекс”-ын шинэчлэлийг эхлүүлээд байна. Шинэчлэн боловсруулсан кодексын төслийг энэ 02 дугаар сард багтааж олон нийтэд танилцуулах тул санхүүгийн зах зээлд оролцогчид холбогдох саналаа ирүүлж, Хорооноос зохион байгуулах хэлэлцүүлэг, сургалтад идэвхтэй оролцохыг зөвлөж байна.

140.2 ХУВИАР ӨСЛӨӨ

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээ, Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооноос боловсруулсан Даатгалын тулгуур зарчим (ICP), зөвлөмжид тулгуурлан, даатгалын компаниудын хөрөнгө оруулалтын удирдлагыг зөв зохистой, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, даатгагчийн хөрөнгийг олон талт хөрөнгө оруулалтад байршуулж, эрсдэлийг тархах зорилгоор Хорооны 2021 оны 64 дүгээр тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл шаардлага”-д холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Тодруулбал Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан компанийн өрийн хэрэгсэлд даатгалын компаниудын хөрөнгө байршуулах дээд хувийг 30 хувь, Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаанд хөрөнгөө байршуулах дээд хувийг 20 хувь байхаар тус тус 10 хувиар нэмэгдүүлсэн юм.

2021 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын бонд, хувьцаа хэлбэрээр хөрөнгийн зах зээлд оруулсан нийт хөрөнгө оруулалт 65.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 140.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс компанийн өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт 2020 оны байдлаар 17.5 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцэст 141.2 хувиар өсч 42.2 тэрбум төгрөг, Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт өмнөх оны үзүүлэлтээс 96.4 хувиар өсч, 10.8 тэрбум төгрөгт тус тус хүрээд байна.

БАЙР СУУРЬ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДҮТӨГ Б.ДОЛГОРСҮРЭН: ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ ЭХЭЛСЭН

Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэнтэй ярилцлаа.



санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмжийн Зөвлөмж 15 / шинэ технологид/-д улс орнууд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын тусгайлсан бодлого зохицуулалтыг бий болгох, хяналт тавих шаардлагатай гэж заасан. Хэдийгээр Монгол Улс нь 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт “саарал жагсаалт”-аас гарсан боловч ФАТФ-ын Зөвлөмж 15-ыг хэрэгжүүлж, виртуал хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулсан үндэсний хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээсэн хэвээр байна.

Түүнчлэн, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь тодорхой тооны харилцагчтай болж их хэмжээний мөнгөн урсгал уг зах зээлээр эргэлдэх болсон ч тусгайлсан эрх зүйн зохицуулалтгүй байсан нь тус технологийн шийдлийг буруугаар ашиглаж эдийн засагт хор хөнөөл учруулах эрсдэлийг нэмэгдүүлж байсан.

Иймд, Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангаж хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, гадаад хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхээс гадна ФАТФ-ын Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах үүднээс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг боловсруулж Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно” гэж заасан. Виртуал хөрөнгийн

Сүүлийн үед блокчэйн суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдацтай өсөн нэмэгдэж иргэдийн зүгээс ч энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөрөнгө оруулах сонирхолтой болсон байна. Энэ төрлийн зохицуулалт манай улсад ямар түвшинд байна вэ? Олон улсад ямар зохицуулалтын шаардлага тавьж байна вэ?

Сүүлийн жилүүдэд дэвшилтэт технологийн үр нөлөө уламжлалт санхүүгийн салбарт шинэчлэлтийг эхлүүлж, үүсэн бий болж буй бүтээгдэхүүн үйлчилгээ нь санхүүгийн инновацыг дэмжиж хүртээмжийг нэмэгдүүлж байна. Нөгөөтээгүүр төвлөрсөн бус системд дундын зуучлагчгүйгээр үйлчилгээ үзүүлэх хязгааргүй боломжийг блокчэйн технологи бий болгосон. Үүнийг дагаад дэлхий дахинд виртуал хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж, зохицуулалтыг тодорхойлох шаардлага үүссэн.

Иймээс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргасан олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг

үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиуд нь “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2022 оны 02 дугаар сарын 14–ний өдрийн №06 дугаарт хэвлэгдсэн бөгөөд 2022 оны 02 дугаар сарын 24–ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлж байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хуулийг олон нийтэд сурталчлах, ач холбогдлыг таниулах, хэрэгжилтийг хангуулах чиглэлд шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хууль батлагдсанаар ямар үр дагавар үүсэж бий болно гэж харж байна вэ?

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, бүртгэх ажил нь инновацыг дэмжих, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Хууль батлагдсанаар талуудын эрх, үүрэг, гэрээний стандарт тодорхой болж иргэд, олон нийт мэдлэг мэдээлэлтэйгээр тус салбарын үйл ажиллагаанд оролцож хохирлоос урьдчилан сэргийлэх боломж бүрдэхээс гадна манай улсад орж ирэх гадаад хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэх, эдийн засгийн эргэлт сайжрах, санхүүгийн зах зээлийн цар хүрээ өргөжин тэлэх зэрэг олон талын эерэг үр дагавартай.

ФАТФ–аас 2021 оны 7 дугаар сард нийтэлсэн “ФАТФ–ын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн шинэчилсэн зөвлөмжийн хоёрдугаар 12 сарын дүгнэлт” баримт бичигт хийсэн судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдсан нийт 128 орноос 58 нь холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байсан. Хууль батлагдсанаар манай улс тус 58 орны нэг болж нэмэгдсэн бөгөөд ингэснээр дэлхийн зах зээлийн хурдацтай хөгжил дэвшилтэй хөл нийцүүлэн алхах боломжийг бидэнд олгож байна.

Түүнчлэн ФАТФ–аас манай улсад 2023 онд хийгдэх ээлжит харилцан үнэлгээнд бэлтгэх ажлыг хангаж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд томоохон ахиц дэвшил болно.

Хууль батлагдсаны дараа ямар алхмуудыг авч хэрэгжүүлэх вэ?

2022 оны 02 дугаар сарын байдлаар нийт 59 виртуал хөрөнгө зах зээлд арилжаалагдсан бол шинээр 24 виртуал хөрөнгийг зах зээлд гаргахаар бэлтгэж байна гэсэн судалгааг Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн. Түүнчлэн давхардсан тоогоор 23 криптовалютын арилжааны платформ үйл ажиллагаагаа явуулж байгаа бол 2 платформыг зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөсөн байна.

Хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын

зохицуулалтын журам боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Журмын төслүүдийг олон улсын судалгаа, ФАТФ–ын стандартад нийцүүлж боловсруулах ажлууд хийгдэж байна. Үүний дараагаар төслийг олон нийтэд нээлттэй байршуулж санал авах ба холбогдох төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хэлэлцүүлгүүд зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Журмыг нэг талаас бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд инновацыг дэмжсэн, нөгөө талаас иргэд, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалсан олон талт эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлсэн байхаар боловсруулахыг зорьж байгаа юм.

Мөн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос шилжилтийн үеийн зохицуулалтыг авч хэрэгжүүлнэ.

Шилжилтийн үед ямар зохицуулалт хийж ажиллах вэ?

Хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 4 сарын хугацаанд аливаа компанийг Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй. Тус 4 сарын хугацаа дуусгавар болсноос хойш 3 сарын дотор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь хуульд заасан шаардлагыг хангаж, Санхүүгийн зохицуулах хороонд 2022 оны 9 дүгээр сарын 24–ний өдрөөс өмнө бүртгүүлнэ. Хууль батлагдсанаар Санхүүгийн зохицуулах хороонд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлээгүй этгээд энэ төрлийн үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй болж байгаа юм.

Виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг юу гэж харж байна вэ?

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх ажлыг анх 2021 оны 02 дугаар сард авч хэрэгжүүлсэн. Виртуал хөрөнгийн зах зээлийн хурдацтай өөрчлөлт, шинэ төрлийн эрсдэлүүд бий болсонтой холбоотойгоор тус эрсдэлийн үнэлгээг шинэчлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороогоор ахлуулсан төрийн зохицуулалтыг хэрэгжүүлж буй нэр бүхий 10 байгууллагын төлөөллийг хамруулсан ажлын хэсгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан. Үүний хүрээнд ажлын хэсгийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг шинэчилж, Дэлхийн банкны аргачлалын дагуу асуулга авч, дата цуглуулах ажлуудыг шат дараалан хийж байна. Эрсдэлийг салбарын болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч тус бүрээр үнэлж гаргана.

2021 оны 12 дугаар сард ФАТФ–ын эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа

явуулж буй нэр бүхий арилжааны платформуудад газар дээрх үзлэг хийж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр баримталж ажиллах заавар, зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотойгоор ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн бэ?

Хэдийгээр хуульд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэснийг тухайн виртуал хөрөнгөд өгч байгаа баталгаа гэж үзэхгүй бөгөөд виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнд үүссэн хохирлыг төр хариуцахгүй байхаар тусгасан ч Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх хүрээнд өөрийн цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр дамжуулан тасралтгүй анхааруулга, мэдэгдлийг хүргүүлж байсан. Тухайлбал, 2021 онд 14 удаагийн анхааруулга, сэрэмжлүүлэг гаргасан бөгөөд иргэдийн сонор, сэрэмж, санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд тодорхой үр нөлөө үзүүлсэн гэж харж байна.

Мөн виртуал хөрөнгө нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд хамрагдах хувьцаа, үнэт цаас, төгрөгтэй адил үнэ цэн бүхий, мөнгөн хөрөнгөөр баталгаажуулахгүй, Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийн шинжийг агуулаагүй, компанийн хөрөнгө, хувьцаа хэлбэрээр баталгаажих боломжгүй тул ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, хохирлыг төр аливаа хэлбэрээр хариуцахгүй болохыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр албан ёсоор мэдэгдсэн.

Цаашид Санхүүгийн зохицуулах хорооноос баримтлах бодлого, стратегийг тодорхойлох, олон улсын байгууллагаас тавьж буй зөвлөмж, шаардлагыг хангах, зохицуулалтын туршлага судлах хүрээнд ФАТФ-ын зөвлөмж, шаардлага, олон улс дахь болон дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, зохицуулалтын орчны судалгаануудыг боловсруулж, бэлтгээд байна.

Үүнээс гадна инновацыг дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын дагуу Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-63/64/32/А/27 дугаар хамтарсан тушаалаар “Сэндбоксыг зохицуулалтын орчны

журам”-ыг баталж, сэндбоксыг зохицуулалтын орчныг бий болгохтой холбоотой ажлуудыг шат дараалан хэрэгжүүлсэн. Тухайлбал, Сэндбоксын нэгж болон зөвлөлийг Санхүүгийн зохицуулах хорооноос байгуулсан бөгөөд 2021 оны 10–12 дугаар сард 3 удаагийн хуралдаан зохион байгуулж Сэндбоксыг зохицуулалтын орчинд орох нийт 7 хүсэлт ирснээс хоёрыг турших шийдвэр гаргасан.

Мөн өмнө дурдсанчлан үзлэгт хамруулах, заавар, зөвлөмж хүргүүлэх, мэдээ, мэдээллээр хангах, хамтран ажиллах чиглэлд арга хэмжээнүүдийг тасралтгүй авч хэрэгжүүлж байна.

Төр хохирлыг хариуцахгүй гэж юу гэсэн үг вэ?

Виртуал хөрөнгийн онцлог нь төвлөрсөн бус, дундын зуучлагчгүй бөгөөд урьдчилан таамаглахад хүндрэлтэй, үнийн савлагаа ихтэй тул аливаа орны төр, засгийн газраас хохирлыг нөхөн төлөх боломжгүй юм. Үүнтэй холбогду олон улсад ч мөн адил санхүүгийн зохицуулагч байгууллагууд виртуал хөрөнгийн эрсдэлийн талаар ард иргэддээ анхааруулсаар байна. Тухайлбал, Английн Санхүүгийн зохицуулах байгууллагаас “...Аливаа төрлийн виртуал хөрөнгийн үйлчилгээ авах, хөрөнгө оруулах нь хөрөнгө оруулагчийн хувьд өндөр эрсдэлтэй бөгөөд бүх хөрөнгө мөнгөө алдахад бэлэн байх ёстой” гэж анхааруулсан. Харин Европын банкнуудын зохицуулах байгууллага, Европын үнэт цаасны зохицуулах байгууллага, Европын даатгалын болон тэтгэврийн зохицуулах байгууллагууд иргэдэд зориулж хамтарсан мэдэгдэл гаргаж, “виртуал хөрөнгө худалдан авах нь өндөр эрсдэлийг дагуулах бөгөөд үнийн савлагаа ихтэй, хамгаалалтын тогтолцоогүй” гэдгийг анхааруулсан.

Манай оронд мөн адил виртуал хөрөнгөнд хөрөнгө оруулсан тохиолдолд учирч болзошгүй эрсдэл, хохирлыг иргэн өөрөө хариуцах юм.

Криптовалютын арилжаанд оролцож буй болон оролцох хүсэлтэй иргэдэд хандаж юу гэж хэлэх вэ?

Богино хугацаанд өндөр ашиг, үр өгөөж амласан виртуал хөрөнгөтэй холбоотой аливаа үйл ажиллагаанаас болгоомжилж, өөрийгөө эрсдэлээс хамгаалахыг анхааруулж байна. Энэ төрлийн үйл ажиллагаанд оролцохоос өмнө иргэд өөрийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, холбогдох мэдээ, мэдээллүүдтэй сайтар танилцаж судалгаа, шинжилгээ хийх, хүлээх эрх, үүрэг, эрсдэлээ бүрэн гүйцэд ойлгосон байх хэрэгтэй.


ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

УУР АМЬСГАЛ, БАЙГАЛИЙН ДОГОЛДЛЫН ЭСРЭГ МОД ТАРИХ ХӨДӨЛГӨӨН

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт Н.Нарантуяа

Нэгдсэн Үндэстний байгууллагаас Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэхэд дэлхий даяар 1 их наяд мод тарих санаачилгыг “Дэлхийн төлөө тарьцаага” ТББ-аас гаргасан. Уг санаачилгын хүрээнд улс орнууд мод тарих хөдөлгөөнд нэгдэж байна.

Европын холбоо нь 3 тэрбум мод тарих стратеги боловсруулсан ба **зөв модыг, зөв газарт, зөв тарих** уриатайгаар хэрэгжүүлж байна. Тус стратегид мод тарих урт хугацааны алсын харааг чухалчилсан ба мод тариад орхилгүй, түүнийг ургаж гүйцтэл арчлахыг иргэн бүрд даалгасан.



Дараагийн чухал асуудал нь мод хаана тарих вэ? гэдэг асуудал юм. Газар төлөвлөлт маш чухал ба мөн засгийн газар, орон нутаг, хувийн хэвшил гээд хамтран ажиллах засаглалыг хэрэгжүүлэх, хойч үедээ мод тарих өв соёлыг өвлүүлэх цогц үйл ажиллагаа хамаардаг.

Хэдийгээр мод тарих хангалттай газар байвч экологийн хувьд ач холбогдол бүхий, мод ургахад таатай газрыг сонгох нь зүйтэй. Чийгтэй, намагтай, зүлэгтэй, их хэмжээний нүүрстөрөгчтэй, биологийн төрөл зүйл амьдардаг газар мод тарьдаггүй.

Үүнд:

- 🌳 Европын холбоо 2030 он гэхэд 3 тэрбум мод тарих шийдвэр гаргаж, одоогийн байдлаар 1.2 саяыг тариад байна.
- 🌳 Пакистан улс цунамигийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор 2015 он гэхэд 1 тэрбум мод тарих ажиллагаа нь амжилттай хэрэгжсэн тул дахин 2030 он гэхэд 10 тэрбум мод тарих хөдөлгөөнийг өрнүүлсэн.
- 🌳 Вьетнам улс нь хар салхинаас сэргийлэхээр 2025 он хүртэл 1 тэрбум мод тарихаар ажиллаж байна.
- 🌳 Шинэ Зеланд улс нийгэм, эдийн засаг, байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахаар 2028 он гэхэд 1 тэрбум мод тарих хөдөлгөөнийг эхлүүлсэн.
- 🌳 Этиоп улс 4 тэрбум мод тарих шийдвэр гаргасан.

МОД ТАРИХ 10 ЗӨВЛӨМЖ



ФИНТЕК БА РЕГТЕК

2021 ОНЫ ФИНТЕКИЙН САЛБАРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД


2021 онд дэлхий даяар финтекийн салбарын нийт хөрөнгө оруулалт 210.1 тэрбум доллар болж өмнөх оноос 68.2 хувиар, нийт хэлцлийн тоо 5,684-д хүрч өмнөх оноос 51.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгө оруулалтын хувьд Их Британийн Refinitiv 14.8 тэрбум доллар, Данийн Nets 9.2 тэрбум доллар, Америкийн Adenza 3.7 тэрбум долларын хөрөнгө оруулалт татаж чадсанаар нийт компаниудыг тэргүүлж байна. Эдийн засгийн бүс нутгаар харахад Америкийн бүс нутаг 105.3 тэрбум долларын 2,660 хэлцэл, EMEA бүс нутаг 77.4 тэрбум долларын 1,859 хэлцэл, Ази Номхон далайн бүс нутаг 27.4 тэрбум долларын 1,165 хэлцэл хийсэн байна.



Дэлхийн венчур капиталын хөрөнгө оруулалт 114.9 тэрбум долларт хүрсэн нь өмнөх оноос 2.5 дахин өсөж түүхэн дээд амжилт тогтоогоод байна. Дижитал чиг хандлага тасралтгүй хурдацтай хөгжиж үүнийг дагаад дижитал болон зайны төлбөр тооцоо, одоо худалдаж ав, дараа төл гэх мэт боломжууд нэмэгдсэнээс үүдэн төлбөрийн салбарын хөрөнгө оруулалт 51.7 тэрбум доллар болж өмнөх оноос 1.8 дахин өссөн гайхалтай жил болж өнгөрлөө. Төлбөрийн салбарт дэлхийн хэмжээний венчур капиталын хөрөнгө оруулалт жил бүр дээд амжилт тогтоож байсан ч нэгдэж, нийлэх үйл ажиллагааны хувьд энэ жилийн хамгийн том хэлцлүүд хийгдсэн. Үүнд Дани улсад төвтэй Nets-ийг Nexi 9.2 тэрбум доллар, Японд төвтэй Paidy-г Payral 2.7 тэрбум долларын хэлцэл хийсэн зэрэг багтсан.

Дэлхийн венчур капиталын хөрөнгө оруулалт 114.9 тэрбум долларт хүрсэн нь өмнөх оноос 2.5 дахин өсөж түүхэн дээд амжилт тогтоогоод байна. Дижитал чиг хандлага тасралтгүй хурдацтай хөгжиж үүнийг дагаад дижитал болон зайны төлбөр тооцоо, одоо худалдаж ав, дараа төл гэх мэт боломжууд нэмэгдсэнээс үүдэн төлбөрийн салбарын хөрөнгө оруулалт 51.7 тэрбум доллар болж өмнөх оноос 1.8 дахин өссөн гайхалтай жил болж өнгөрлөө. Төлбөрийн салбарт дэлхийн хэмжээний венчур капиталын хөрөнгө оруулалт жил бүр дээд амжилт тогтоож байсан ч нэгдэж, нийлэх үйл ажиллагааны хувьд энэ жилийн хамгийн том хэлцлүүд хийгдсэн. Үүнд Дани улсад төвтэй Nets-ийг Nexi 9.2 тэрбум доллар, Японд төвтэй Paidy-г Payral 2.7 тэрбум долларын хэлцэл хийсэн зэрэг багтсан.

Зураг. Нийт финтекийн хөрөнгө оруулалт



2021 онд рэгтекийн нийт хөрөнгө оруулалт 9.9 тэрбум доллар болсон бөгөөд Канадад төвтэй Верафин 2.7 тэрбум доллар, Ирландад төвтэй Fenergo 600.0 сая доллар, Карта 500.0 сая долларын хөрөнгө оруулалт татсан байна. Мөн 2021 онд хэд хэдэн

Зураг. Нийт венчур капиталын хөрөнгө оруулалт



хууль эрх зүйн зохицуулалтын байгууллагууд рэгтек шийдлийг чухалчлан авч үзсэн. Сингапурын Мөнгөний газар санхүүгийн үйлчилгээний салбарын хиймэл оюун ухааны чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн санаачилгыг эхлүүлсэн бөгөөд үүнд NovA! – санхүүгийн байгууллагуудад байгаль орчны эрсдэлийг үнэлэхэд туслах техникийн платформ, Veritas – санхүүгийн байгууллагуудад хиймэл оюун ухаан болон өгөгдлийн аналитикийг ашиглахад туслах зорилготой хөтөлбөр, Хонг Конгийн Мөнгөний газар рэгтекийг хөгжүүлэх, нэвтрүүлэхийг дэмжих зорилгоор мөнгө угаахтай тэмцэхэд төвлөрсөн рэгтек лабораторийг нээсэн.



Цахим аюулгүй байдлын хөрөнгө оруулалт 4.8 тэрбум доллар болж огцом өссөн. Тухайлбал томоохон Ransomware халдлагууд, мэдээллийн технологийн дэд бүтцэд ашиглагдаж болох аюултай программуудтай холбоотой үйлдлүүд хэд хэд гарсан нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж байна.

Крипто болон блокчэйн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж 2020 онд 5.4 тэрбум доллар байсан бол 2021 онд 30.0 тэрбум гаруй доллар болж нэмэгджээ. Дэлхий даяар орчин үеийн санхүүгийн системд крипто болон түүний суурь технологиудын гүйцэтгэх үүрэг тэдгээрийн хэрэгцээг хүлээн зөвшөөрч байна. Хөрөнгө оруулагчид блокчейн орон зайд хурдацтай дасан зохицож эхэлсэн бөгөөд энэ нь өнөөдрийн санал болгож буй үнэ цэнийг хараад зогсохгүй маргаашийн боломжуудыг нээж байна.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ХОЛБОО ХАМААРЛААС ҮҮСЭХ СИСТЕМИЙН ЭРСДЭЛ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа narantuya@frc.mn

ХУРААНГУЙ

Холбоо хамаарлаас үүсэж болох системийн эрсдэл, тэдгээрийн төрлүүдийг тодорхойлохыг энэхүү судалгааны ажлаараа тодорхойлохыг зорилоо. Манай улсын хувьд холбоо хамаарлын эрсдэл нь санхүүгийн групп компани, банк хоорондын зах зээл, санхүүгийн байгууллагууд хоорондын өр, авлагын сүлжээгээр холбогдож үүсдэг байна.

Түлхүүр үгс: системийн эрсдэл, холбоо хамаарлын эрсдэл, сүлжээний шинжилгээ

JEL ангилал: D81, G18

ТАНИЛЦУУЛГА

Хямрал нь нэг талдаа эдийн засгийн уналтын доод цэг байдаг бол нөгөө талаасаа циклээс циклийн хоорондох шилжилт байдаг. 2019 оны сүүлээр дэгдсэн коронавирусийн цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн бүхий л салбар хямралд орж, хүн бүхний амьдралд нөлөөлсөн. Үүнээс улбаатайгаар дэлхийн эдийн засгийн өсөлт 6 хувиар саарч, 1929 оны Их хямралаас хойших анхны их хэмжээний уналт нүүрлэв. Их хямрал, Азийн хямрал, 2009 оны санхүүгийн хямрал, цар тахлын хямрал гээд дэлхийг доргиосон уналт, түүний нөлөө давтамжтайгаар тохиолдсоор байдаг.

Түүнчлэн дэлхийн гадаад худалдаагаар дамжин улс орнууд хоорондын эдийн засгийн үйл ажиллагаа бие биеэсээ хамаарах байдал нэмэгдэж, технологийн дэвшлийн нөлөөгөөр орон зайнаас үл хамааран хувь хүн, байгууллагууд ч хоорондоо холбоотой байх болсон. Үүнийг глобалчлал гэж нэрлэх болсон бөгөөд түүний нөлөөгөөр системийн эрсдэл үүсэж улмаар олон улсыг хамарсан хямралыг бий болгож байна. Ойрын жишээнээс дурдвал 2009 оны санхүүгийн хямрал, коронавирусын цар тахал юм.

Санхүүгийн зах зээл дэх системийн эрсдэлийг үүсгэдэг нэг хүчин зүйл нь холбоо хамаарлын (interconnectedness) эрсдэл ба санхүүгийн байгууллагууд хоорондын шууд ба шууд бус хамаарлаас үүсдэг. Холбоо хамаарлын эрсдэл нь нэг санхүүгийн байгууллагын уналт хөрөнгөөр холбогдсон нөгөө санхүүгийн байгууллагыг эрсдэлд оруулахыг хэлнэ. 1990 оноос хойш улс орнууд, төдийгүй санхүүгийн байгууллагууд хоорондоо нягт холбогдсон.

Шууд хамаарал нь санхүүгийн байдлын тайлангаар холбогдсон хамаарал, түүнчлэн банк болон бусад санхүүгийн байгууллагуудын хадгаламж, зээл зэрэг олон сувгаар холбогдсон байхыг хэлнэ. Тухайлбал групп компани хоорондын хөрөнгийн хэлхээ, санхүүгийн байгууллагууд хоорондын өр, авлагын сүлжээ, банк хоорондын гүйлгээний бие биеэсээ хамааралтай байдал нь холбоо хамаарлаас үүдэлтэй системийн эрсдэлийг үүсгэнэ. Групп компанийн холбоо хамаарал өндөр байхыг системийн хувьд ач холбогдол бүхий дампуурахын аргагүй холбоо хамааралтай групп гэж нэрлэдэг. (Lelyveld & Schilder, 2002) нар санхүүгийн групп нь орлогыг нэмэгдүүлж, зардлыг хэмнэдэг, эрсдэл үүрэх хөшүүрэг үүсгэдэг давуу талтай ч зах зээлийн төвлөрөл, ашиг сонирхлын зөрчил болон дампуурах эрсдэлийг үүсгэх сул талтай гэж дүгнэжээ.

Холбоо хамаарлын эрсдэлийн шууд бус нөлөө нь зах зээл дэх хөрөнгө оруулалттай холбоотой үнийн алдагдал, мэдээллийн тархах нөлөө, зах зээл, хөрөнгө оруулагчдын зан төлөвөөс хамаардаг.

Манай улсын хувьд санхүүгийн байгууллагууд хоорондын холбоо хамаарал групп компани, банк хоорондын зах зээл, даатгалын компаниудын хөрөнгийн байршил, өр, авлагын сүлжээгээр үүсэж байна. Санхүүгийн байгууллагууд групп компани хэлбэрээр уг зах зээл дэх бүх салбарт үйл ажиллагаа явуулах болсон нь 1999 оноос санхүүгийн зах

зээлийн хяналт, зохицуулалтыг АНУ-аас бууруулснаар санхүүгийн групп компаниуд үүсэх болсон ба манай улсад 2011 онд Банкны тухай хуульд арилжааны банкнуудыг банкны салбараас бусад санхүүгийн зах зээлийн салбарт үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн нэмэлт өөрчлөлтийг оруулснаар уг тогтолцоо бий болсон. Санхүүгийн зах зээлд санхүүгийн групп компаниудын зах зээлд эзлэх хувь их хэмжээгээр нэмэгдсэн ба өнөөгийн байдлын талаар “Санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын тогтолцоо” (Санхүүгийн зохицуулах хорооны судалгааны товхимол No.1) судалгаагаар тодорхойлсон.

Энэхүү судалгааны ажлаар санхүүгийн групп компаниуд, банк бус санхүүгийн байгууллагуудтай зээлийн эх үүсвэрээр санхүүгийн байгууллагууд болон даатгалын компаниудын хөрөнгийн байршлаар тэдгээрийн хоорондын холбоо хамаарлыг харуулахыг зорилоо.

Түүнчлэн санхүүгийн группийг хянаж, зохицуулах аргачлалыг “Олон улсын төлбөр тооцооны банк”, “Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага”-аас гаргасан зөвлөмжийг удирдлага болгон, Японы Санхүүгийн үйлчилгээний агентлагийн “Санхүүгийн групп компанийг хянах гарын авлага”-аас оруулав.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлтөөс үүдэлтэй санхүүгийн хямралын үеэр зарим компаниуд дампуурахын аргагүй том байхад, харин зарим нь дампуурахын аргагүй хоорондоо холбогдсон байсан. Үүний сацуу тэдгээрийн хоорондын холбоо хамаарлыг олох, үнэлэх судалгаанууд хийгдэх болсон.

Олон улсын валютын сангаас улс орнуудын санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг үнэлэхдээ сүлжээний шинжилгээний аргачлалыг ашигладаг. Уг аргачлал нь төвлөрсөн болон кластер шинжилгээ, балансын тайлангийн симуляцын аргаас бүрдэнэ.

(Huser, Anne-Caroline) нар санхүүгийн байгууллагууд хоорондын холбоо хамаарлаас үүсэх системийн эрсдэлийг банк хоорондын сүлжээний загвар (interbank network model)-ыг ашиглаж үнэлгээ хийсэн. Банк хоорондын сүлжээний загварт тодорхойгүй байдал, холбоотой талуудын эрсдэл, хөрвөх чадварыг авч үздэг.

(Taufiq Hidayat, 2016) Индонез Улсад 29 санхүүгийн групп компани нийт хөрөнгөөрөө зах зээлийн 77 хувийг эзэлдгийг судалж, TOPSIS (Technique For Order Preference By Similarity

To An Ideal Solution) загварыг ашиглан санхүүгийн гүйцэтгэлийг үнэлж, арилжааны банкнаас санхүүгийн групп нь илүү сайн гүйцэтгэлтэй байдгийг судалгаагаараа харуулсан.

(Henrard, Luc, and Ruben Olieslagers, 2004) банк болон даатгалын группийн эрсдэлийн удирдлагын зургаан үе шатыг тодорхойлж, эрсдэлийн таксономиг гаргасан.

(Wilmarth, Arthur E, 2002) АНУ-ын 1990-ээд оны санхүүгийн группүүд төдийгүй бусад улсуудын санхүүгийн группүүд дампуурахад энгийн банкнаас илүү их хохирол учруулж, мөн тэдгээр нь өөрийн даах хэмжээнээс илүү эрсдэлийг үүрдэг ба үүнд групп дэх санхүүгийн байгууллагууд хооронд галт ханыг босгох нь чухал гэж дүгнэжээ.

(Bricco, Mrs Jana, and Ms TengTeng Xu) нар холбоо хамаарлын эрсдэлийг үнэлэх зураглал буюу санхүүгийн систем, банк болон салбар хоорондын холбоо хамаарлыг зураглаж системийн эрсдэлийг тодорхойлсон. Уг аргачлалдаа тулгуурлан Олон улсын валютын сангийн гишүүн орнуудын санхүүгийн системийн холбоо хамаарлын үнэлгээг хийсэн.

(Arregui, M. N., Norat, M. M., Pancorbo, A., Scarlata, J. G., Holttinen, E., Melo, F & Yanase, M. (2013)) нар сүлжээний шинжилгээнд төвлөрсөн, кластер шинжилгээ болон балансын симуляцын арга гэсэн 3 төрлийн хэрэгсэл ашигласан.

(Moghadam, Reza, and Josy Vinals) судалгаагаараа олон улс дахь зээл ихтэй 8 улс болох Франц, Герман, Япон, Нидерланд, Испани, Швейцар, Их Британи болон АНУ хоорондын холбоо хамаарлыг сүлжээний шинжилгээний аргачлалаар тооцсон. Эдгээр улсуудын зээлсэн санхүүжилтийн 60 хувь нь хил дамнасан банкнуудаас санхүүжилт татсан ба Австрали, Австри, АНУ хамгийн өндөр хамааралтай байна.

(Candelon, Bertrand, Laurent Ferrara, and Marc Jolts) нар 13 хөрөнгийн зах зээл хоорондын холбоо хамаарлыг шугаман бус босго онооны вектор авторегрессийн загвараар үнэлсэн. Ингэснээрээ олон улс дахь хөрөнгийн зах зээлийн холбоо хамаарлын түвшнийг тодорхойлсон.

(Korobilis, Dimitris, and Kamil Yilmaz) нар Бэйсийн вектор авторегрессийн загварыг ашиглан санхүүгийн байгууллагууд хоорондын холбоо хамаарлын индексийг тооцсон.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

(Bricco, Mrs Jana, and Ms TengTeng Xu) нар холбоо хамаарлын шинжилгээг дараах гурван үе шаттайгаар хийх аргагүйг боловсруулсан:

Санхүүгийн системийн зураглал;

Банк болон салбар хоорондын холбоо хамаарлыг үнэлэх / interbank analysis, cross-sectoral analysis, cross-border analysis, exposure data, market data/;

Санхүүгийн зах зээл дэх системийн эрсдэл.

“Санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын тогтолцоо” судалгаагаар санхүүгийн системийг зурагласан. Харин банк болон салбар хоорондын холбоо хамаарлыг (Espinosa-Vega, Marco A., and Mr Juan Sole) нарын боловсруулсан 3 алхамт аргачлалыг ашиглан тодорхойлов.

Зээл болон хөрвөх чадварын шокийн симуляц

$$\sum_j x_{ji} + a_i = k_i + b_i + d_i + \sum_j x_{ij}$$

Тайлбар:

x_{ji} – банк i -ийн банк j -д олгосон зээл

a_i – банк i -ийн бусад хөрөнгө

k_i – банк i -ийн өөрийн хөрөнгө

b_i – богино болон урт хугацаат зээл /банк хоорондын зээл хамаарахгүй/

d_i – хадгаламж

x_{ij} – банк i -ийн банк j -ээс авсан зээл

Зээлийн шокийн шилжилт

Зээлийн шокийн нөлөөг үнэлэхийн тулд банк тус бүрийн алдагдал үүсэхэд гарах дефолт (loss given default)-ыг тооцно.

$$a_i + \sum_{j \neq i} (2) (1 - \gamma)x_{ni} = (k_i - \gamma x_{ni}) + b_i + d_i + \sum_j x_{ij}$$

ХОЛБОО ХАМААРЛЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Системийн эрсдэлийг макро зохистой бодлогын арга хэрэгслээр удирддаг ба санхүүгийн тогтвортой байдлыг хангахад мөнгөний болон сангийн бодлого, микро зохистой бодлогын гүйцээвэр гэж үздэг. Макро зохистой бодлогын хүрээнд эмзэг байдлыг хөшүүргийн, хөрвөх чадвар болон зах зээлийн эрсдэлийн, холбоо хамаарлын түвшинд

удирддаг.

Холбоо хамаарлын эрсдэлийг санхүүгийн байдлын тайланд төвлөрлийг хязгаарлах, системийн эрсдэлд сан үүсгэх ба тэдгээрийг банк хоорондын өр төлбөр, хөрөнгө, гаргасан үнэт цаас гэсэн үзүүлэлтүүдээр тооцно. Санхүүгийн холбоо хамаарал дахь мэдээллийн тэгш бус байдал нь системийн эрсдэлийг үүсгэдэг тул ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах шаардлагатай.

Санхүүгийн групп компанийн хяналт, зохицуулалт

Санхүүгийн групп компаниуд нь гурван төрлийн эх үүсвэрээс үүдэлтэй буюу балансын гадуурх тайлагнал, төвлөрөл, системийн ач холбогдол бүхий компаниудаас эхлэлтэй дараах төрлийн эрсдэлүүдийг үүсгэдэг.

1. Группийн эрсдэл
2. Группийн бүтцийн цогц байдал
3. Системийн нөлөө бүхий
4. Ил тод байдлын эрсдэл: Хэлцлийн хөрвөх чадварын нөлөөлөл, групп доторх компани хоорондын хэлцлийг үнэлэх боломжгүй байдал
5. Халдварлах нөлөөллийн эрсдэл

Япон улс нь зайбацу буюу групп компаниудад түшиглэж эдийн засгийн голлох салбарууд үүсэж хөгжсөн байдаг. Харин санхүүгийн групп компаниудыг Санхүүгийн үйлчилгээний агентлагаас хянаж зохицуулдаг ба тэдгээрт зориулсан групп компанийн хэмжээнд үүсэж болох эрсдэлээ удирдах гарын авлагатай.

Санхүүгийн ба санхүүгийн бус групп компанийг хянах:

- Санхүүгийн группийг тодорхойлох
- Санхүүгийн ба санхүүгийн бус группийг хянах 3 үе шат:
- a. Санхүүгийн компанийн хяналт
 - b. Нэгдсэн хяналт шалгалт
 - c. Санхүүгийн группийг бүхэлд нь хянах

Зохицуулалтын стандарт:


- 1) Институтийн стандарт
- 2) Группийн стандарт
- 3) Тоон стандарт
- 4) Чанарын стандарт

Зохистой стандартыг тогтоох

Санхүүгийн групп компанид тусгай капиталын зохистой харьцааны шаардлагыг гаргах

Давуу тал	Сул тал
Өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ	Халдварлах нөлөө
Эдийн засгийн үр өгөөж нэмэгдэнэ	Группийн уналт
Дэд бүтцийн хөгжил	Ил тод байдлын дутмаг байдал
Түгээлтийн суваг	Чанарын удирдлага
Тансаг хэрэглээний бүтээгдэхүүний диверсификаци	Зохистой мэдээлэлд олж авах боломж
Мэдээллийн хялбар нэвтрэлт	Ёс зүйн гажуудал

Зураг. Санхүүгийн групп компанийн хяналт, зохицуулалт



САНАЛ, ДҮГНЭЛТ

Манай улсын хэмжээнд системийн эрсдэлийг үүсгэх нэг хүчин зүйл нь холбоо хамаарлын эрсдэл ба санхүүгийн ба санхүүгийн бус групп компаниуд, даатгалын компаниудын хөрөнгийн байршлаар үүсэх холбоо хамаарал, ББСБ-ууд хооронд болон арилжааны банкнаас авсан зээл гэсэн гурван эх үүсвэрээс үүсэх магадлалтайг тодорхойллоо.

Цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд санхүүгийн групп компанид зохистой харьцааг тооцож, тогтоох, эсвэл эрсдэлийн тохиромжтой тооцооллыг боловсруулах нь зүйтэй. Түүнчлэн Японы Санхүүгийн үйлчилгээний агентлагаас санхүүгийн групп компаниудад зориулан гаргасан шиг гарын авлага нэвтрүүлэх нь зүйтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Arregui, Mr Nicolas, et al. "Addressing interconnectedness: Concepts and prudential tools." (2013).

Bricco, Mrs Jana, and Ms TengTeng Xu. Interconnectedness and contagion analysis: a practical framework. International Monetary Fund, 2019.

Candelon, Bertrand, Laurent Ferrara, and Marc Jolts. "Global financial interconnectedness: a non-linear assessment of the uncertainty channel." *Applied Economics* 53.25 (2021): 2865–2887.

Diebold, Francis X., and Kamil Yilmaz. "Better to give than to receive: Predictive directional measurement of volatility spillovers." *International Journal of forecasting* 28.1 (2012): 57–66.

Espinosa-Vega, Marco A., and Mr Juan Sole. Cross-border financial surveillance: a network perspective. International Monetary Fund, 2010. <https://www.imf.org/external/pubs/ft/wp/2010/wp10105.pdf>

Freixas, Xavier, Gyungyi Lyrónth, and Alan D. Morrison. "Regulating financial conglomerates." *Journal of Financial Intermediation* 16.4 (2007): 479–514. <https://www.jbs.cam.ac.uk/wp-content/uploads/2020/08/wp0706.pdf>

Gatzert, Nadine, and Hato Schmeiser. "On the risk situation of financial conglomerates: does diversification matter?." *Financial Markets and Portfolio Management* 25.1 (2011): 3–26.

https://www.vworm.rw.fau.de/files/2016/05/1260618997_Diversification_2009-08-13.pdf

Hidayat, Taufiq. "The impact of financial conglomeration on risk and return performance in Indonesia banking industry." (2016). https://www.um.edu.my/library/oar/bitstream/123456789/72129/1/The_impact_of_financial_conglomeration_on_risk_and_return_performance_in_Indonesia_banking_industry.pdf

Henrard, Luc, and Ruben Olieslagers. "Risk management of a financial conglomerate." *FORUM FINANCIER-REVUE BANCAIRE ET FINANCIERE BANK EN FINANCIEWEZEN*-. LARCIER, 2004.

<https://www.soa.org/globalassets/assets/library/newsletters/risk-management-newsletter/2004/march/rm-2004-iss01-henrard-olieslagers.pdf>

Hyser, Anne-Caroline. "Too interconnected to fail: A survey of the interbank networks literature." (2015). https://www.econstor.eu/bitstream/10419/203293/1/safe-wp-091_3.pdf

Korobilis, Dimitris, and Kamil Yilmaz. "Measuring dynamic connectedness with large Bayesian VAR models." *Available at SSRN 3099725* (2018).

Moghadam, Reza, and Josy Vinals. "Understanding financial interconnectedness." *IMF Policy Paper* (2010).

Segoviano Basurto, Miguel, and Charles Goodhart. "Banking stability measures." (2009). <https://www.imf.org/external/pubs/ft/wp/2009/wp0904.pdf>

Third World Network. Risk concentrations in financial conglomerates. 26 May 2008 <https://twm.my/title2/finance/twninfofinance20080508.htm>

Wilmarth, Arthur E. "How should we respond to the growing risks of financial conglomerates?." *Available at SSRN 291859* (2001). <https://core.ac.uk/download/pdf/232645619.pdf>

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ



Ээлжит болон ээлжит бус
хуралд оролцох, санал өгөх



Компанийн тайлан
мэдээлэлтэй танилцах



Эрх ашгаа хамгаалуулах
талаар гомдол гаргах

ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭХ ЗААВАР



Яаж данс нээдэг
юм бол доо?
.....

Би танд
заагаад өгье.



01

Та өөрт тохиромжтой
брокерын компанийг
сонгоно.

02

Брокер дээр очиж,
эсвэл цахимаар
дансаа нээлгэнэ.

03

Хамгийн сүүлд нь данс
нээлгэх хураамжаа
/5,000–10,000/ төлөөд л
болоо



АНХААРАХ ЗҮЙЛС:

- Мэдээллээ үзэн зөв бөглөх, мэдээллээ алдахаас сэргийлэх
- Гарын үсгээ зурахаас өмнө арилжааны шимтгэлийн хувь **/1–3%/**, хугацаа зэргийг сайтар анхаарах
- Арилжаанд орохдоо тухайн хувьцааны талаар судлах



ХУВЬЦАА ГЭЖ ЮУ ВЭ?

Хувьцаа гэдэг нь: компанийн тодорхой хэсгийг эзэмших эрхийг хэлэх буюу компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас юм.

ХУВЬЦААНЫ ТӨРЛҮҮД

Үнэт цаас гаргагч компани **үндсэн 2 төрлийн** хувьцааг санал болгодог.

01

Энгийн хувьцаа /common stock/

Энгийн хувьцаа эзэмшигч ихэнхдээ тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох бөгөөд ногдол ашиг авах эрхтэй.

Давуу эрхийн хувьцаа /preferred stock/

Давуу эрхийн хувьцаа эзэмшигч саналын эрхгүй боловч тогтмол хэмжээний ногдол ашгийг энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж авах эрхтэй.

02

ХУВЬЦААНЫ ДАВУУ БА СУЛ ТАЛ

Давуу тал



1. Хөрвөх чадвар сайн
2. Ханшийн зөрүүнээс ашиг олох
3. Хувьцааны үнэ цэн өсөх магадлал их
4. Ногдол ашиг хүртдэг
5. Хөрөнгөө өөрөө удирдах боломжтой



Сул тал

1. Хөрөнгө үнэ цэнээ алдах
2. Удаан хугацааны хүлээлт
3. Хадгаламжид байснаас эрсдэл өндөртэй
4. Гадаад, дотоод олон хүчин зүйлсээс хамаардаг
5. Компани нь дампуурах эрсдэлтэй

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛД СУРАЛЦЬЯ (ХИЧЭЭЛ №3)



Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.ЭНХБААТАР

Мөнгөний цаг хугацааны үнэ; ирээдүйн ба одоогийн үнэ

Өмнөх хичээлд нэг жил хүртэлх богино хугацааны хөрөнгө оруулалтын ирээдүй ба одоогийн үнийг хэрхэн тооцоолохыг заасан. Энэ хичээлээр та бүхэнд урт хугацааны хөрөнгө оруулалтыг хэрхэн тооцох талаар та зааж өгье.

Урт хугацааны хөрөнгө оруулалт

Богино хугацааны хөрөнгө оруулалтын ирээдүйн үнэ цэнийг тооцоход “энгийн хүү”-гийн нөхцөлөөр (хугацааны дараа нэг удаа хүү тооцогдох) боддог. Хэрэв хөрөнгө оруулалтын хугацаа нэг жилээс их, хүүг жил бүрийн эцэст тооцоолон үндсэн хөрөнгө оруулалт (эсвэл хадгаламж) дээр нэмэгдүүлэх нөхцөлд тооцооллыг “нийлмэл хүү”-гийн аргаар бодно.

3 жилийн хугацаатай, 10% хүүтэй 100 төгрөгийн ирээдүйн үнэ цэнийг дараах байдлаар тооцоолно:

$$₮100 \times (1+0.10)^3 = ₮133.10$$

Энэ тэнцлээс, 3 жилийн дараах 10% хүүтэй 133.10 төгрөгийн өнөөгийн үнийг тооцох тэнцлийг доорх байдлаар илэрхийлнэ:

$$\frac{133.10}{(1 + 0.10)^3} = 100$$

Дээрх тэнцлээс мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тооцох ерөнхий томъёолол дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

$$\frac{C}{(1+i)^n}$$

$$FV = PV \times (1+i)^n \quad PV = \frac{FV}{(1+i)^n} \quad i = \left(\frac{FV}{PV}\right)^{\frac{1}{n}} - 1$$

PV (present value) – өнөөгийн үнэ цэнэ

FV (future value) – ирээдүйн үнэ цэнэ

C (cashflow) – мөнгө

i (interest) – хүү

n (number of years) – хугацаа (жил)

Жишээ бодлого 1:

120 төгрөгийн жилд 8% хүүтэй 5 жилийн дараах ирээдүйн үнэ цэнийг олъё.

$$120 \times (1+0.08)^5 = 176.32$$

(жил бүр тооцогдох хүүг дараагийн жил мөн хөрөнгө оруулсан гэж тооцон нийлмэл хүүгийн аргаар тооцсон)

Жишээ бодлого 2:

7% хүүгийн өгөөжтэй 4 жилийн дараах ₮270 –ийн өнөөгийн үнэ цэнэ хэд вэ?

$$\frac{270}{(1 + 0.07)^4} = 205.98$$

Жишээ бодлого 3:

7% хүүтэй 180 хоногийн дараа хуримтлагдсан 270 төгрөгийн өнөөгийн үнэ цэнийг олъё.

$$\frac{270}{(1 + 0.07 \times \frac{180}{365})} = 260.99$$

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН 2022 ОНЫ ТОП-10 ЧИГ ХАНДЛАГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)-ИЙН ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ

ТУЗ нь итгэл хүлээх, гүйцэтгэх удирдлагын багт дуу хоолойгоо хүргэх асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай байна. ТУЗ-ийн үр нөлөөг гүйцэтгэх удирдлага хэрхэн харж байгааг судалсны үндсэнд захирлын үүрэг хариуцлагатай холбоотой асуудлууд үүсэж байна. Эдгээр асуудлууд захирлуудыг ТУЗ-ийн ажилд хангалттай цаг зарцуулж байгаа эсэхээ эргэн харахыг сануулж байгаа юм.

ТУЗ/ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ДИНАМИК

ТУЗ-ийн гишүүдэд илүү их итгэл хүлээлгэхийг уриалж буй гаднын хүчин зүйл нь ТУЗ/гүйцэтгэх удирдлагын динамик тогтвортой байдалд дарамт учруулах болно. ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагууд үүрэг, хариуцлага, эрх мэдлийн заагаа эргэн харж ТУЗ-ийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэх удирдлагын үүрэгтэй хэрхэн тэнцвэржүүлэхийг тодорхой болгох хэрэгтэй.

БИЗНЕСИЙН УЯН ХАТАН БАЙДАЛ

ТУЗ-үүд гүйцэтгэх удирдлагын бизнесийн уян хатан байдлаа нэмэгдүүлэх оролдлогыг нь дэмжиж, урамшуулах хэрэгтэй. Ковид-19-ийн өсөлт, эдийн засгийн тогтворгүй байдалтай уялдуулан ойрын хугацааны зохион байгуулалтын арга хэмжээг үргэлжлүүлж, "дахин төсөөлөх" санаачилгыг хэрэгжүүлж болно. Гэхдээ Ковид-19-ийн нөхцөл байдлаас хамааран уян хатан байдлын төлөвлөлтийг өөрчлөх шаардлагатай болно.

ХҮМҮҮН КАПИТАЛ

ТУЗ нь ажиллах хүч, ажил олгогчийн уламжлалт харилцааны асуудлуудтай үргэлжлэн тулгарах болно. Энэ нь ажилчдын соёлыг байгууллагын хөрөнгө болгож, ажлын байрны аюулгүй байдал, ажлын байрны нөхцөл, нийгэм улс төрийн асуудлуудыг шийдвэрлэхэд тавих хяналт зэрэг илүү өргөн хүрээг хамарна. Хамгийн гол нь ажлаас ихээр гарах үзэгдлийг өдөөж буй хүчин зүйлс, ажлын ёс зүй, тууштай ажиллахад үзүүлэх нөлөөлөлд удирдлагын хэрэгжүүлж буй арга хэмжээг удирдан чиглүүлэх, дэмжих явдал юм.

ҮРГЭЛЖИЛСЭН ESG (БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ) ХЯНАЛТ

Хөрөнгө оруулагч, хэрэглэгчид болон засгийн газрын дарамт шахалтад хариу үйлдэл үзүүлэхийн тулд ESG-тэй холбоотой асуудалд (ялангуяа уур амьсгалын өөрчлөлт ба хүмүүн капитал) анхаарлаа хандуулсаар байх болно. ТУЗ-ийн гишүүд ESG-ийн хүлээлт, гүйцэтгэл болон үүрэг хариуцлагыг цаашид боловсронгуй болгох тал дээр гүйцэтгэх удирдлагатай хамтран ажиллахад бэлэн байх ёстой.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН

Аж үйлдвэрийн салбаруудад хиймэл оюун ухааны хэрэглээ хурдацтай нэмэгдэж байгаа тул хяналтын дараах 2 асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Нэгдүгээрт, өөрсдийн компанидаа хиймэл оюун ухааныг ашиглах, хэрэгжүүлэх асуудалд бэлтгэх, түүнчлэн ТУЗ-ийн сургалт, хяналт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бий болгосон дотоод бүтэц, хоёрдугаарт, хиймэл оюун ухаан болон ТУЗ-ийн харилцан үйлчлэлд шууд нөлөөлөхүйц хууль тогтоомж, зохицуулалт, шилдэг туршлагыг хөгжүүлэх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМД ХЯНАЛТ ТАВИХ

Байгууллагын ёс зүйн дүрэм болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагуудын гаргасан зөрчлийг үнэлэх үйл явцад илүү их хяналт тавих хэрэгтэй. Цаашлаад ажлын байрны соёл, гүйцэтгэх удирдлагын багийн ашиг сонирхол зэрэг ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг тэнцвэржүүлэхийн тулд ТУЗ-ийн гишүүд илүү анхаарах болно.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ДУУ ХООЛОЙ

2022 онд гарч болзошгүй улс төр, нийгмийн маргаантай асуудлууд нь ТУЗ-ийн аливаа шийдвэр гаргалтад хүндрэл учруулах болно. Хөрөнгө оруулагчид компанийн нийгмийн хариуцлага, идэвх, улс төрийн холбоо ялангуяа ил тод байдлыг илүү шаардаж байна.

ЗОРИЛГЫН ЧУХАЛ ЭРСДЭЛҮҮД

Гүйцэтгэх удирдлагын зүгээс компанийн зорилготой

холбоотой эрсдэлийн талаар ТУЗ-д мэдээлэл өгөх тайлагналын системийн хүлээлт нэмэгдэж байна. Үүний хариуд ТУЗ-үүд компанийн үйл ажиллагааны аль тал нь тухайн стандартад нийцэж байгааг хянаж, гүйцэтгэх удирдлагын тайлангийн хэлбэр, бүтцийг тогтоож, чухал эрсдэлүүд гарах үед ТУЗ-ийн хариуцлагын талаар гүйцэтгэх удирдлагатай нэгдсэн ойлголтод хүрэх ёстой.

КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛ, ХЯНАЛТ

ТУЗ-өөс дотоод хяналт, тайлагнах механизмын хүрэлцээг дахин үнэлэх хэрэгтэй болно. Үүнтэй холбоотойгоор гүйцэтгэх удирдлагуудын комплаинсын эрсдэлийг тайлагнах, комплаинсын тогтолцоог бий болгохыг дэмжих хэрэгтэй. Харин ТУЗ нь эрсдэл үнэлэх чадвараа баталгаажуулж, сайжруулах хэрэгтэй.

Эдгээр болон бусад чиг хандлага нь ТУЗ-ийн үйл ажиллагаа, манлайллын үүргээ хэрэгжүүлэх арга хэлбэрт нөлөөлөх магадлалтай. 2022 онд ТУЗ-үүд өөрсдийн зан байдал, туршлага, үйл ажиллагааны арга барилаа шаардлагатай бол өөрчилж, шинэчлэх замаар арга хэмжээ авч болно.

Эх сурвалж: Forbes



ХЭРЭГЛЭГЧ

2021 ОНЫ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТАЙЛАН

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1–д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Санхүүгийн зохицуулах хороонд хандаж, ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, санал, дүгнэлт гарган хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2021 онд албан бичгээр болон цахимаар нийт 699 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр буюу цаасаар нийт 475 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч тайлант хугацаанд 454 өргөдлийг шийдвэрлэж, 21 өргөдөл хуулийн хугацаанд хянаж байна. Цахимаар ирүүлсэн 224 өргөдөл гомдолд хариу өгч, утсаар болон ажлын байран дээр ирсэн 2206 иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Албан бичгээр буюу цаасаар нийт 475 өргөдөл, гомдол ирүүлснийг дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

№	Салбар	2020 он	2021 он
1	Даатгал	269	201
2	Үнэт цаас	130	143
3	ББСБ	90	84
4	ХЗХ	10	21
5	Бусад	–	26
	Нийт	499	475

Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоог өмнөх онтой харьцуулахад 4.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдлын тоог өмнөх онтой харьцуулахад даатгал 25.3 хувь, банк бус санхүүгийн байгууллага 6.7 хувиар тус тус буурсан бол, үнэт цаасны зах зээл 10.0 хувиар, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоо 2.1 дахин өссөн байна.

Санхүүгийн зохицуулах хороонд 2020 он болон 2021 онд ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар урьдчилан шийдвэрлэв.

Өргөдөл, гомдлыг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал, даатгалын нөхөн төлбөр, даатгалын хураамж, үнэт цаасны бүртгэл, ББСБ–ын үйл ажиллагаа, лавлагаа болон бусад асуудалтай холбоотой гомдол тус тус буурч, ББСБ–ын зээлийн гэрээ, хүү тооцоолол, зээлийн мэдээллийн сан, ХЗХ–ны үйл ажиллагаатай холбоотой маргаан тус тус өссөн дүнтэй байна.

Санхүүгийн зохицуулах хороонд нийт ирж буй үнэт цаастай холбоотой өргөдөл гомдлын тоо 2020 оноос өссөн байгаа нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ШӨХТГ–аас “Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, ягаан цэнхэр тасалбартай холбоотой асуудлыг шалгана”, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК–д харилцагчдын их хэмжээний мөнгө тараагдаагүй төвлөрч байна” гэх мэт мэдээллээс үүдэн иргэд өмнө нь тухайн асуудлаар хандан Санхүүгийн зохицуулах хорооноос албан бичгээр хариу өгсөн асуудлаар дахин хандах байдал нэлээд ихэссэн байна. Хувьцааг харилцагчийн зөвшөөрөлгүй арилжсантай холбоотой өргөдөл, гомдлын 52.4 хувийг хувьцаа худалдах захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөл, мөнгө олгосон тайланд нэр бүхий иргэний гарын үсэг зурагдсан өргөдөл гомдол эзэлдэг бөгөөд гарын үсэг зурагдсан бол тухайн гарын үсгийг хуурамч эсэхийг эрх бүхий байгууллагаар тогтоолгох талаар зөвлөж, 2000 оноос өмнө тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компани олдохгүй байгаа талаар, ХК ногдол ашиг авахгүй байгаа болон татан буугдсан, дампуурсан, дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, гомдолд дурдсан асуудал нь тухайн үеийн хуулиар зөрчилд тооцогддоггүй байсан, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзэн гомдлыг хүлээн авахаас татгалзаж, уг асуудлаар хуулийн байгууллагад хандуулахаар урьдчилан шийдвэрлэсэн.

Даатгалтай холбоотой нийт өргөдөл гомдлын 66.2 хувийг нөхөн төлбөртэй холбоотой гомдол эзэлж байгаа нь даатгалын талаар иргэдийн мэдлэг, ойлголт муугаас үүдэн даатгалын тохиолдол үүссэн даруй даатгагчид мэдэгдээгүй, даатгалын тохиолдлыг нотлоогүй,

Д/д	Өргөдөл, гомдлын утга	2020 он	Эзлэх хувь	2021 он	Эзлэх хувь
ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ					
1	Жолоочийн хариуцлагын даатгал	67	25	23	11.4
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	104	38.7	64	31.8
3	Орон сууц зээлдэгчийн эрсдэлийн даатгал	2	0.7	-	-
4	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал /ипотек/	41	15.2	64	31.8
5	Хөрөнгийн даатгал	20	7.4	15	7.5
6	Мал амьтдын даатгал	-	-	-	-
7	Ачаа, тээврийн даатгал	1	0.4	-	-
8	Хариуцлагын даатгал	3	1.1	9	4.5
9	Санхүүгийн даатгал	-	-	2	1.0
10	Зээлийн даатгал	11	4.1	4	2.0
11	Хуримтлалын даатгал	-	-	-	-
12	Эрүүл мэндийн даатгал	1	0.3	-	-
13	Агаарын хөлгийн даатгал	-	-	-	-
14	Итгэлцлийн даатгал	3	1.1	-	-
15	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	16	6	20	10.0
		269	100	201	100
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ					
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	42	32.3	40	27.9
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээлэл шалгуулах	22	16.9	20	14.0
3	Хувьцааг шилжүүлэх, шилжүүлэн авах	11	8.5	-	-
4	Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг	8	6.2	14	9.8
5	Хөрөнгө оруулалтын сан	11	8.5	6	4.2
6	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	30	23.1	57	39.9
7	Бусад	6	4.6	6	4.2
		130	100	143	100
ББСБ					
1	Зээлийн мэдээллийн сангийн бүртгэл	29	32.2	40	47.6
2	Зээлийн гэрээний маргаан, хүүгийн тооцоолол	20	22.2	4	4.8
3	ББСБ-ын үйл ажиллагаа	25	27.8	20	23.8
4	Лавлагаа болон зохицуулалтын бус	12	13.3	5	6.0
5	Барьцаа хөрөнгө	4	4.4	2	2.4
6	Бусад	-	-	6	7.1
7	Зээлийн хүүгийн тооцоолол	-	-	7	8.3
		90	100	84	100
ХЗХ					
1	Лавлагаа гаргуулах	3	30	3	14.3
2	Хадгаламж буцаан олгоогүй	-	-	1	4.8
3	ХЗХ-ны үйл ажиллагаа	7	70	7	33.3
4	Гэрээний маргаан	-	-	10	47.6
		10	100	21	100
Нийт		499	100	475	100

даатгуулаагүй жолооч нь шуурхай албанд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй, даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй зэргээс үүдэн даатгалын нөхөн төлбөр авах боломжгүй байдал үүссэнтэй холбоотой өргөдлүүд байна.

Даатгагчийн зүгээс үндэслэлгүйгээр нөхөн төлбөрийг хасаж олгосон, хууль тогтоомж болон гэрээнд заагаагүй аливаа шаардлага, хязгаарлалт тавих, бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахдаа даатгуулагчид бүтээгдэхүүний талаар танилцуулга хийлгүйгээр гэрээ хийх, гэрээний нөхцөлийг өөрчлөх даатгалын гэрээнд даатгалын зүйлийн талаарх мэдээллийг зөрүүлж бичсэн зэрэг зөрчил дутагдал байна. Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, харилцагчийн хохирол

барагдуулах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан даатгалтай холбоотой 89 иргэн, хуулийн этгээдэд 833,710,748 төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор урьдчилан шийдвэрлэсэнээс, даатгагч 29 иргэн, хуулийн этгээдэд 117,209,587 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан байна.

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор ирүүлсэн өргөдөл, гомдлын 47.6 хувийг зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй холбоотой гомдлууд эзэлж байгаа бол Хадгаламж зээлийн хоршоотой холбоотой ирүүлсэн өргөдлийн 47.6 хувийг ногдол ашиг, 33.3 хувийг үйл ажиллагаатай холбоотой гомдол тус тус эзэлж байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Дэлхий даяар инфляцын түвшин өндөр байна.

ОУВС-аас гаргасан тайланд инфляц дэлхий даяар өсөж буй шалтгаануудыг томоохон улс орон, бүс нутгуудаар нь ангилан гаргасан байна. Тухайлбал, шатахуун, хүнсний үнийн өсөлт болон боомтууд дахь бөөгнөрөл, ложистикийн гацаа зэргээс үүдэн инфляц хөөрөгдөж байна.

Европт газрын тос, бензиний үнэ, байгалийн хийн үнэ өнгөрсөн онтой харьцуулахад бараг 2 дахин өсөөд байгаа нь хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хамгийн ихээр нөлөөлж байна. АНУ-ын хувьд бараа бүтээгдэхүүний эрэлт өссөн ч нийлүүлэлтэд үүсээд буй саатал инфляцын гол шалтгаан болж байгаа бол Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад импортын барааны үнийн өсөлт инфляцыг нь өндөр түвшинд хүргэж байгаа юм.

01 дүгээр сард гарсан “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд дурдсанаар “Инфляцын өсөлт урт хугацаанд үргэлжлэх хэдий ч хэрвээ тогтвортой байвал 2023 оноос буурч магадгүй” гэжээ.

“Brent” нефтийн үнэ 96 ам.доллар давжээ.

Лондоны ICE бирж дээр “Brent” маркийн нефтийн фьючерс хэлцлийн нэг торхны үнэ нь 2021 оны дөрөвдүгээр сараас 1.7 хувиар нэмэгдэж 96.07 ам.доллар болсон байна.

2014 оны 10 дугаар сарын 01-ний өдөр “Brent” нефтийн үнэ 96.0 ам.доллараас давж байжээ.

2021 оны сүүлчээр нефтийн эрэлт хоногт 5.6 сая торхоор нэмэгдсэн байна. Эрэлт нэмэгдсэнээр байгалийн хийн үнийн өсөлт нөлөөлсөн. Олон улсын эрчим хүчний агентлагийн шинжээчид “2022 онд нефтийн эрэлт хоногт 3.3 сая торхоор нэмэгдэж, 100.6 сая баррель болно” гэж таамаглаж байна.

Их Британийн ДНБ өнгөрсөн онд 7.5 хувиар өсжээ.



Их Британийн дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ 2021 онд 7.5 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт нь тус улсын хувьд дэлхийн II дайнаас хойших хамгийн өндөр өсөлт болсон байна.

Тус улсын Засгийн газрын зүгээс омикрон хувилбарын тархалтыг хязгаарлах арга хэмжээ авсан нь иргэдийн зарцуулалт буурсан.

Харин 2020 онд цар тахлын дэгдэлт эхэлж байх үед тус улсын ДНБ 9.4 хувиар буурсан нь хамгийн том уналт болсон.


Европын Холбоо ОХУ, Израил, Бермудийг саарал жагсаалтад оруулахаар төлөвлөж байна.

Европын Холбоо /ЕХ/ нь ОХУ, Израил, Бермуд, Британийн Виржиний арлуудыг саарал жагсаалтад оруулахаар төлөвлөж байгаа тухай баримт бичгийн төслийг “EUobserver” дурдсан байна. Тус хэвлэлд мэдээлснээр, ЕХ-ны сайд нар жагсаалтын шинэчилсэн хувилбарыг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр батлах төлөвлөгөөтэй байгаа юм. Жагсаалтад улс орнуудыг оруулах шалгуурт өөрчлөлт оруулснаар өөр 10 улс нэмэгдэх төлөвтэй байна.

Саарал жагсаалтад татварын бодлогодоо шинэчлэл хийнэ гэсэн ч өөрчлөлт хийгээгүй улсуудыг оруулдаг бол татварын чиглэлээр ЕХ-той хамтран ажиллахаас татгалзсан эсвэл татварын тогтолцооны дутагдалтай улс орнуудыг “хар жагсаалт”-д оруулдаг. Хар жагсаалт нь татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх давуу талтай юм.

2021 онд Бээжинд дижитал юаниар хийсэн гүйлгээний хэмжээ 1.5 тэрбум ам.доллараас давжээ.

БНХАУ-ын нийслэл Бээжин хотын Санхүүгийн хяналтын газрын орлогч дарга Ван И “Өнгөрсөн онд цахим үйлчилгээнд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан, дижитал юаниар хийсэн



гүйлгээний хэмжээ 9.6 тэрбум юаньд хүрсэн. Дижитал юаниар төлбөр хийх боломжтой туршилтын цэгүүдийн тоо хурдацтай нэмэгдэж байгаа” гэж хэвлэлийн бага хурлын үеэр мэдээлжээ.

“Дасин” олон улсын нисэх онгоцны буудал болон аялал жуулчлалын Ванфүжин гудамжнаас эхлээд өвлийн Олимпын наадмын байгууламжуудын нийт нутаг дэвсгэрт дижитал юаниар төлбөр хийх боломжтой 400,000 гаруй цэг бий. Бээжинд

энэхүү виртуал валютаар төлбөр хийх газруудын тоо цаашид улам нэмэгдэнэ" гэж Ван Ин нэмж хэлжээ.

Хятад улс 2019 оны сүүлчээр дижитал юанийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд тус туршилтын төсөлд олон хот нэгдсэн байна. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар төлбөр тооцооны энэ хэрэгслээр төлбөр хийх боломжтой цэгийн тоо тус улсад 3.5 саяд хүрсэн бөгөөд Бээжингийн өвлийн олимпын наадам нь дижитал юанийн хөгжлийг шинэ шатанд хүргэнэ гэж таамаглаж байна.

БНХАУ газрын ховор элементийн хомстолд оржээ.

Мьянмараас нийлүүлэлт тасалдсан болон цахилгаан тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаатай холбоотойгоор Хятад улс газрын ховор элементийн хомстолд орж эхэлжээ.

"Global Times" сонинд мэдээлснээр, БНХАУ-д түүхий эдийн үнэ 2022 оны 01 дүгээр сард жилийн дунджаас 14.0 хувиар өссөн байна.

БНХАУ-ын билгийн тооллоор тэмдэглэдэг Шинэ жилийн баярын дараа орон нутгийн компаниуд, ялангуяа зүүн нутгийн Жянси мужийн компаниуд газрын ховор элементийн олборлолтоо эрс нэмэгдүүлжээ. "Олборлолтын хэмжээг баярын өмнөх түвшинд хүргэсэн. Эрчим хүчний өөр эх үүсвэрээр ажилладаг хөдөлгүүр, машин үйлдвэрлэгчдийн эрэлт хэрэгцээ тогтмол нэмэгдэж байна" гэж Хятадын уул уурхайн компани мэдээлжээ.

Албан ёсны статистик мэдээгээр, 2021 онд Хятадад цахилгаан хөдөлгүүрт автомашины борлуулалт 181.0 хувиар нэмэгдэж, 3.3 сая гаруй болсон байна.

АНЭУ криптовалютын зах зээлийг зохицуулах систем нэвтрүүлнэ.

Арабын Нэгдсэн Эмирт Улсын /АНЭУ/ эрх баригчид криптовалютын зах зээлийг зохицуулах цогц системийг 2022 оны эхний улирал дуусахаас өмнө боловсруулж дуусгахаар төлөвлөж байгаа талаар "Bloomberg" агентлаг мэдээлжээ.

Эх сурвалжийн мэдээлснээр "АНЭУ-ын Үнэт цаасны газар виртуал хөрөнгийн чиглэлээр үйлчилгээ үзүүлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг удахгүй дуусгана. Зөвшөөрлийг тус улсын эдийн засгийн зарим чөлөөт бүсэд олгож эхэлсэн байгаа. Тухайлбал, Дубайн олон нэр төрлийн түүхий эдийн төвийн 22 компанид, Абу-Дабигийн дэлхийн захад 6 зөвшөөрөл олгосон байна".

АНЭУ-ын эрх баригчид виртуал хөрөнгийг хянахдаа хослуулсан аргыг хэрэглэхээр төлөвлөж байна. Тодруулбал, Үнэт цаасны газар нь Төв банктай хамтран криптовалютын биржүүдийн үйл ажиллагааг зохицуулах бол орон нутгийн санхүүгийн төвүүд тусгай зөвшөөрөл олгох журмыг өөрсдөө гаргахаар болсон.

Алтны үнэ 2021 оны 6 дугаар сараас хойших хамгийн дээд түвшинд хүрсэн байна.

Нэг унц алтны үнэ 2021 оны 6 дугаар сарын 11-нд 1,900 ам.доллар байсан бол "Comex" биржийн 2022 оны 02 дугаар сарын 17-ны арилжааны явцад алтны үнэ 1.64 хувиар өсөж, нэг унц нь 1,902.2 ам.долларт хүрчээ. Алтны үнэ өсөхөд АНУ-ын өндөр инфляц, Украиныг тойрсон хямрал нөлөөлж байна гэж шинжээчид үзэж байна.

Тус нөлөөллийн үр дүнд Японд алтны үнэ түүхэн дээд хэмжээнд хүрсэн гэж NHK телевиз мэдээлжээ. Алтны гол арилжаа явагддаг Осакагийн түүхий эдийн биржийн цахим хуудсанд мэдээлснээр, 02 дугаар сарын 21-ний өдөр нэг грамм алтны үнэ 7040 иен буюу 61 гаруй ам.долларт хүрсэн нь уг бирж байгуулагдсанаас хойших хамгийн өндөр үнэ юм.

"Украины эргэн тойронд үүссэн түгшүүртэй байдал нь хувьцаа болон бусад үнэт цаасны үнэ буурахад нөлөөлж, валютын зах зээл дээр тогтворгүй байдал үүсгэж байна" гэж NHK телевиз мэдээлсэн байна. Үүнтэй холбоотойгоор "Олон хөрөнгө оруулагчид алт, түүнчлэн газрын тос, үр тариатай холбоотой фьючерс хэлцэлд хөрөнгө оруулахыг илүүд үзэж байна" гэж онцлон тэмдэглэжээ.




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 02 дүгээр сарын 22-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,304.76 -44.11 (-1.01%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


27,241.31 -461.26 (-1.71%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,494.20 +9.88 (+0.13%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,381.52 -166.55 (-1.23%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

